

Иргэд үйлчлүүлэгчдэд
зориулсан мэдээлэл

Шулуун гэдэс болон Үтрээгээр эм хэрэглэх арга:



➤ **Шулуун гэдэсний лааг хэрэглэхийн тулд дараах журмаар ажиллана. Үүнд:**

1.Гараа угаана.
2.Савлагаанаас гаргана.(лаа зөөлрөөгүй байвал савлалтаас шууд гаргах бөгөөд хэрэв зөөлөрсөн бол хөргөгчид хийх буюу хүйтэн усанд барьж хатуувтар болгосны дараа гаргана).

3.Хурц үзүүртэй болсон байвал бага зэрэг бүлээсгэн үзүүр, ирмэгийг арилгана.

4.Лаагаа хүйтэн усанд норгоно.

5.Нэг талаараа хэвтэн дээд талынхаа хөлийг өвдгөөрөө нугална.

6.Лааг хошноого руугаа аажим эргүүлж оруулна.

7.Хэвтээгээрээ цөөн минут байна.

8.Гараа угаана.

9.Нэг цагийн дотор хүндээр бие засаж болохгүй.

➤ **Лаа хэлбэрийн эмийг үтрээгээр хэрэглэхийн тулд дараах журмаар ажиллана. Үүнд:**

1. Гараа угаана.

2. Лааг савлагаанаас гаргана.

3. Лаагаа хүйтэн усанд норгоно.

4. Дээшээ харж хэвтээд өвдгөө нугалан алцайна.

5. Лааг үтрээ рүү болгоомжтой аль болох гүн оруулна.Харин хүчилж болохгүй.

6. Хэвтээгээрээ аль болох удаан байна.

7. Гараа угаана.

Хамар эм дусаах болон цацаж хэрэглэхийн тулд та дараах журмыг баримтлах хэрэгтэй. Үүнд:



1. Гараа угаана.
2. Эхлээд нусыг нийлгэж хамрыг цэвэрлэнэ.
3. Өвчтөнийг суулгаж сайтар гэдийлгэнэ.
4. Дусаагуурт эмийг соруулна. Хэрэв эм бэлэн дусаагуур бүхий саванд савлагдсан бол тагийг авч бэлтгэнэ.
5. Дусаагуурыг хамрын нүхэнд нэг см орчим оруулна.
6. Жоронд заасны дагуу эмийг дусаана.
7. Дараа нь шууд толгойг өвдөгний хооронд хүртэл бөхийлгөнө.
8. Цөөн секунд болоод өндийж суухад дусал залгиур руу орно.
9. Амаар амьсгалуулна.
10. Хамрын нөгөө нүхэнд эм дусаах бол дээрх үйдлийг мөн давтан хийнэ.
11. Буцалсан усаар дусаагуураа зайлж цэвэрлэх ба эмийг таглан хадгална.


Аэрозол эмийг хэрэглэхдээ дараах зааврын дагуу ажиллах хэрэгтэй.Үүнд:



- 1.Гараа угаана.
- 2.Ханиаж цэрээ сайтар гарган амьсгалын замыг аль болох чөлөөтэй болгоно.
- 3.Аэрозолоо гарган сэгсэрч хэрэглэхэд бэлтгэнэ.
- 4.Уруулын орчимд эмийнхээ аман талын хэсгийг байрлуулна.
- 5.Толгойг бага зэрэг гэдийлгэнэ.
- 6.Амьсгалыг сайтар гарган уушгийг аль болох суллана.
- 7.Хэлийг дээш болгоод амьсгалаа гүн авахдаа аэрозолоо шахна.
8. 10-15 секунд амьсгааг түгжинэ.
- 9.Хамраар амьсгална.
10. Амаа бүлээн усаар зайлна.



- *Нүдэнд эм дусаах болон тосон түрхлэгийг хэрэглэхийн тулд дараах журмыг баримтлах хэрэгтэй.*




1. Гараа угаана.
2. Өвчтөнөө дээш харуулан хэвтүүлэх эсвэл толгойг гэдийлгэх
3. Дусаагуур болон тосны тагийг нээн дусаах, түрхэхэд бэлтгэнэ.
4. Эм дусаах, тос түрхэх нүдний доод зовхийг татаж доод зовхинд суваг гаргана.
5. Дусаагуураа нүдэндээ хүргэлгүйгээр нүдний доод зовхинд үүсгэсэн сувагт эмийг жоронд бичигдсэн хэмжээгээр дусаах
6. Хоёр минут орчим нүдийг зөөлөн аниулна.
7. Илүүдэл шингэн болон тосыг цэвэр алчуураар арчина.

Нүдний дуслыг хэрэглэхэд бага зэрэг халуу оргих мэтийн мэдрэмж үүсч болох боловч энэ нь цөөхөн минутын дараа хэвийн болох ёстой. Хэрэв ийм мэдрэмж хэт удаан үргэлжлэх буюу өөр сөрөг нөлөө илэрвэл эмчид хандах хэрэгтэй.

➤ ***Нүдэнд эм дусааж хэрэглэхдээ анхаарах зүйлс***

- Дусаагуур болон тосон түрхэцийн хошууг янз бүрийн талбайд шүргэхээс сэргийлэх
- Хоёроос дээш эм дусаах нөхцөлд хооронд нь 10 минутын зайтай хийх
- Нэг эмийг хоёроос дээш дусаах тохиолдолд 3-5 мин-ын зайтай дусаах
- Дусаагуурыг хэрэглэхийн өмнө 10 секунд сэгсэрч, бүлээсгэх

Чихэнд эм дусааж хэрэглэхийн тулд дараах журмыг баримтлах хэрэгтэй.Үүнд:



1. Гараа угаана.
2. Өвчтөний толгойг хажуу тийш хазайлгах буюу эсвэл хажуугаар нь хэвтүүлнэ.
3. Чихний дэлбээг зөөлөн татаж чихний нүхийг чөлөөтэй болгоно.
4. Жоронд бичигдсэн хэмжээгээр чихний нүх рүү эмийг дусаана.
5. Хэрэв үйлдвэрлэгчээс зөвлөсөн бол эмээ дусаасны дараагаар чихний сувгаа хөвөнгөөр бөглөнө.
6. Чихний дусал цөөн хэдэн минутаас илүү хугацаагаар халуун оргиулж хорсгох ёсгүй.

✚ Чихэнд эм дусааж хэрэглэхдээ анхаарах зүйлс

- Чихэнд дусааж хэрэглэх эм бүхий савыг халуун гараар атгаж буюу сугандаа цөөн минут хавчуулж бага зэрэг бүлээсгэнэ. Халуун усанд бүү дүр
- Эмийг дусаасны дараа 3-5 мин толгойг хажуу тийш хазайлгаж байна.
- Хэрэв нөгөө чих рүү эм дусаах бол эхний чихэнд эм дусаасны дараа 5-10 минут болсны дараа нөгөө чихэнд дусаана.
- Насанд хүрэгчид болон 3-аас дээш насны хүүхдэд эм дусаахдаа чихний дээрээс бага зэрэг татаж дусаана.
- 3-аас доош насны хүүхдэд эм дусаахдаа чихний доод омгоос доош нь татаж дусаана.

Бэлтгэсэн:

НТТТөв

Баянзүрх салбар
Эмийн сан